




2024 7-р сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

Наадмын дараах налгар өдрүүд дууссан намрын эхлэл цагийг угтаж 7-р сарын онцлох үйл явдлууд болон голлох макро статистик үзүүлэлтүүдтэй танилцацгаая.

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ 2.5 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН АШИГТАЙ ГАРЧЭЭ.

- 2024 оны эхний хагас жилд нийт экспорт 7.9 тэрбум ам.доллар, нийт импорт 5.4 тэрбум ам.доллар буюу гадаад худалдааны тэнцэл 2.5 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан ч импортын өсөлт экспортын өсөлтийг хэд дахин давсны нөлөөгөөр өмнө оны мөн үеэс ашгийн хэмжээ 22 хувиар буурсан байна.

ЭКПОРТ, ИМПОРТЫГ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГЭЭР НЬ АВЧ ҮЗЭХЭД:

- Нийт импорт өмнө оны мөн үеэс 26 хувиар өссөн ба барааны бүлгээр өсөлтийн хувийг хуваан авч үзвэл хүнд оврын машин механизм болон барилгын материалын импортын өсөлт 14 хувийг, хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортын өсөлт 6 хувийг, шатахууны импортын өсөлт 4 хувийг голлон бүрдүүлжээ. Суудлын авто машины импорт өмнөх оны мөн үеэс 25,000 ширхэг буюу мөнгөн дүнгээр 42.4 хувиар өссөн байна. Мөн дизелийн түлшний импорт 137,000 тонноор буюу мөнгөн дүнгээр 24.2 хувиар өссөн.
- Харин нийт экспорт өмнө оны мөн үеэс ердөө 5 хувиар буюу 383 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд өмнө оны мөн үеэс нүүрсний экспорт 344 сая ам.доллараар, зэсийн экспорт 125 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин зуд ихэссэнтэй холбоотой малын хорогдлоос шалтгаалж ХАА-н бүтээгдэхүүний экспорт өмнө оны эхний хагас жилтэй харьцуулахад 108 сая ам.доллараар буурсан байна.
- Цаашлаад нийт нүүрсний экспорт өссөн боловч нүүрсний хилийн үнэ буурсан хэвээр байна. 2024 оны эхний хагас жилд нүүрсний биет хэмжээ 39 сая тонн-д хүрсэн нь өмнө оны мөн үеэс 11 сая тонн-оор буюу 40 хувиар өссөн хэмжээ боллоо. Гэсэн хэдий ч хилийн үнэ өмнө оны эхний хагас жилтэй харьцуулахад 22 хувиар буурч тонн тутамд 153 ам.доллараас 119 ам.доллар боллоо.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ 351 САЯ АМ.ДОЛЛАРЫН АШИГТАЙ ГАРСАН Ч ӨМНӨ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД БУУРЧЭЭ.

- Дотоод хэрэглээний өсөлтөөр импорт өссөнөөр гадаад худалдааны тэнцэл буурч төлбөрийн тэнцэл буурахад нөлөөлж байна. 5-р сард төлбөрийн тэнцэл 351 сая ам.долларын ашигтай гарсан ч өмнө оны мөн үетэй харьцуулахад 150 сая ам.доллараар буурчээ. Цаашлаад импортын өсөлтөөр валютын гарах урсгал нэмэгдэж урсгал дансны алдагдал эхний таван сарын байдлаар өмнө жилийн мөн үеэс 740 сая ам.доллараар буурч 470 сая ам.долларт хүрсэн байна.

ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ 6-Р САРД 4.8 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРЛЭЭ.

- Төлбөрийн тэнцэл буурч байгаа нөлөөгөөр гадаад валютын албан нөөц 5-р сард 5.2 тэрбум ам.долларт хүрч байсан бол 6-р сард өмнөх сараас 6.6 хувиар буурч 4.8 тэрбум ам.доллартой гарав. Ийнхүү 2024 он гарснаас хойших хамгийн доогуур хэмжээнд хүрлээ. Монголбанкнаас өнгөрсөн сард Хятадын ардын банктai хийсэн своп хэлцлээс 4.5 тэрбум юань буюу 617 сая ам.долларын своп арилжаа хийснээ мэдээлсэн ба энэ нь нөөцийн хэмжээ буурахад мөн нөлөөлжээ.
- Улмаар эхний хагас жилийн байдлаар валютын нөөцийн хэмжээ дунджаар 5 сарын импортыг хангах түвшинд байна. Энэ тоо 2020 онд хамгийн өндөр буюу эхний хагас жилийн байдлаар 8 сарын импортыг хангах түвшинд байжээ.

ИНФЛЯЦЫН ТҮВШИН 6-Р САРД УЛСЫН ХЭМЖЭЭНД 5.1 ХУВЬТАЙ ГАРСАН БАЙНА.

- Олон улсын зах зээлд үнийн өсөлт буурч байгаа нөлөөгөөр хэрэглээний бараа бүтээгдэхүүний дийлэнхийг импортын бүтээгдэхүүн эзэлдэг манай улсад инфляц буурч байна. Импортын барааны үнэ өмнө оны мөн үеэс 35.3 хувиар өссөн буюу инфляцад 1.8 нэгж хувиар нөлөөлсөн байна. Инфляцад нөлөөлөх импортын барааны үнийн өсөлт 2022 онд 58.6 хувь, 2023 онд 35.8 хувьтай байжээ.
- Инфляцыг барааны бүлгээр задлан авч үзвэл боловсролын үйлчилгээний үнийн өсөлт хамгийн өндөр буюу өмнө оны мөн үеэс 17 хувиар өсжээ. Цаашлаад өмнө оны мөн үетэй харьцуулахад хүнсний бараа 4,7 хувь, хувцас 5.4 хувь, гэр ахуйн бараа 5.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 6.6 хувь, зочид буудлын үнэ 6.9 хувиар тус тус өссөн байна. Аялал жуулчлалын улирал эхэлсэнтэй холбогдуулан ийнхүү зочид буудал, хоолны газрын үнэ өндрөөр өсжээ.
- Хэдий инфляц зорилтот түвшинд хүрсэн ч геополитикоос хамаарсан гадаад эрсдэлүүд үргэлжилж байгаа учраас 7-р сарын мөнгөний бодлогын хорооны хурлаар Монгол банкнаас бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Мөн банкнуудын гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг гурван нэгж хувиар бууруулж, 15 хувьд хүргэх шийдвэр гаргасан юм. Энэхүү шаардлага нь 2021 оноос хойш 18 хувиар тогтоогдож байв.

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД ЮУ ГЭЖ БАЙНА?

- FITCH олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагаас 2024 онд эдийн засгийн өсөлтийг 7 хувьд хүрнэ гэж өмнөх 4 хувийн төсөөллөө ахиуллаа. FITCH байгууллагаас сонгуулийн үр дүнд МАН эрх баригч намаар сонгогдсонтой холбогдуулах урт хугацааны бодлого болон хөрөнгө оруулалт үргэлжилж уул уурхайн салбараар эрчимжсэн эдийн засгийн өсөлт хурдасна гэж үзжээ. Мөн тус байгууллагаас засгийн газрын зардал болон дотоодын эрэлт нэмэгдэж байгаа учраас урсгал дансны алдагдал 2024 оны эцэст ДНБ-ий 4 хувь, төсвийн алдагдал ДНБ-ий 1 хувьтай тэнцэнэ гэсэн төсөөлөлтэй байгаа аж.
- Харин Дэлхийн банкнаас 6-р сарын шинэчлэгдсэн тайландаа Монгол улсын эдийн засгийн өсөлтийг 2024 онд 4.8 хувь, 2025 онд 6.6 хувьд хүрэх таамаглал дэвшүүлжээ. Үүнд голчлон уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, хувийн хэрэглээ сэргэн, төсвийн зардал тэлэлттэй байгаа нөлөөлөх аж.
- АНУ-ын холбооны нөөцийн сангаас бодлогын хүүг бууруулах шийдвэрээ хойшлууллаа. Мөн хэдийгээр хойшлуулж эхлэх хугацаа тодорхойгүй байна. ХНС-ийн ерөнхийлөгч Жэром Паулл-ын мэдэгдлийн дагуу инфляц зорилтот хоёр хувийн түвшинд баттай ирэх хүртэл бодлогын хүүг бууруулах шийдвэрээ азнах ба 2024 он дуусахаас өмнө бодлогын хүүг 2 удаа бууруулах шинжээчдийн хүлээлтэд тодорхой байр суурь илэрхийлээгүй байна.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТҮҮХЭН ДЭЭД ӨСӨЛТ?

- 2024 оны эхний хагас жилд мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ өмнө оны мөн үеэс 32 хувиар нэмэгдэж 41 их наяд төгрөгт хүрлээ. Ийнхүү мөнгөний нийлүүлэлт түүхэн дээд хэмжээгээр буюу нэг жилийн дотор арван их наядаар нэмэгдэв. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 85 гаруй хувийг төгрөгийн харилцах, хадгаламж голлон бүрдүүлсэн бол үлдсэн хувийг валютын харилцах дансны өсөлт бий болгожээ.
- Банкны салбарын нийт зээл болон харилцах, хадгаламж мөн түүхэн дээд хэмжээнд өслөө. 2024 оны эхний хагас жилд өмнө оны мөн үетэй харьцуулахад нийт зээл 8.0 их наяд төгрөгөөр, нийт харилцах, хадгаламж 10.3 их наяд төгрөгөөр өссөн байна. Өөрөөр хэлбэл 2024 он гарснаас хойш хагас жилийн дотор нийт зээл 6.1 их наяд төгрөгөөр өсөж 33.6 их наяд төгрөгт, нийт харилцах, хадгаламж 3.9 их наяд төгрөгөөр өсөж 42.8 их наяд төгрөгт хүрлээ. Уул уурхайн салбараар эрчимжсэн экспортын өсөлт үргэлжилж байгаа болон 4-р сараас эхлэн цалин, тэтгэврийн хэмжээ нэмэгдсэнээр дотоод эрэлт өсөж ийнхүү зээл, харилцах хадгаламж нэмэгдэхэд голлон нөлөөлж байгаа ажээ.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024Q1	2023Q4	2023Q1	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	6,065	30,454	5,624	7.8%
Ажилгүйдлийн түвшин	%	5.20%	3.92%	6.62%	-21.5%
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,284	2,235	1,831	24.7%
Гадаад өр	сая ам доллар	35,003	34,570	33,563	4.3%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M06	2024M05	2023M06	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	7,947	6,417	7,564	5.1%
Зэс	сая ам доллар	1,454	1,151	1,330	9.4%
Нүүрс	сая ам доллар	4,675	3,817	4,331	7.9%
Нийт импорт	сая ам доллар	-5,378	-4,395	-4,274	25.9%
Хэрэглээ	сая ам доллар	-1,522	-1,258	-1,245	22.3%
Түүхий эд	сая ам доллар	-466	-382	-398	16.9%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	-2,322	-1,837	-1,744	33.1%
Шатахуун	сая ам доллар	-1,060	-910	-880	20.4%
Тэнцэл	сая ам доллар	2,569	2,022	3,291	-21.9%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	9,648	10,117	8,397	14.9%
Нүүрс	\$/тонн	144	148	139	3.5%
Газрын тос	\$/баррель	83	83	75	10.6%
Алт	\$/трой унц	2,328	2,351	1,945	19.7%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	1,101	1,882	1,548	-28.9%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	14,012	11,926	10,581	32.4%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	-12,911	-10,044	-9,034	42.9%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M06	2024M05	2023M06	
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	41,467	39,074	31,448	31.9%
ХҮИ (C2015)	индекс	145.4	145.0	138.4	5.1%
Бодлогын хүү	%	11.0%	11.0%	13.0%	-15.4%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,381	3,381	3,433	-1.5%
Төгрөгийн хадгаламж	%	11.6%	11.4%	10.9%	6.5%
Валютын хадгаламж	%	2.9%	4.6%	2.8%	3.4%
Төгрөгийн зээл	%	17.1%	16.9%	16.9%	1.4%
Валютын зээл	%	11.0%	9.3%	9.8%	11.8%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	4,839	5,183	3,812	26.9%
Үнэт цаас	сая ам доллар	2,615	2,663	607	330.5%
Харилцах, хадгаламж	сая ам доллар	1,531	1,916	2,704	-43.4%
ОУВС-д байршуулсан хөрөнгө	сая ам доллар	7	7	7	-1.6%
Зээлжих тусгай эрх	сая ам доллар	96	97	114	-15.3%
Мөнгөжсөн алт	сая ам доллар	590	500	379	55.6%

БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ны өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ



Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ



Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Дархлан

Цахим хаяг: darkhlan@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.